



**НОМУУН БЭХИ АУДИТ ХХК**

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ийн 2022 оны  
12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон  
санхүүгийн тайлангийн тухай**

Улаанбаатар хот 2023 он



НОМУУН БЭХИ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо  
Энх тайваны өргөн чөлөө, Гео төв 508 тоот  
Утас: 77112488, 99096345, 94006880  
И-мэйл: nomuunbekhi@gmail.com

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН  
УДИРДЛАГАД

2023 оны 02 сарын 27 өдөр

№ ДГ-21-23

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй үнэн зөв толилуулсан байна.

### Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт найдаж байна.

### Санхүүгийн тайлангийн талаархи компаний Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Сангийн яамнаас гаргасан холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх



мөрдөх, нягтлан бодох хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хүлээнэ. Засаглах удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын процесст хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийлэлийг байнга илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар зөвлөмж өгч ажиллана. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба материаллаг алдаа нь хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэл болж болзошгүй гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

“НОМУУН БЭХИ АУДИТ” ХХК-ЫН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.УНДРАХ


2023 оны 02 сарын 27



**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК  
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2022 оны 12-р сарын 31	/төгрөгөөр/	
БАЛАНСЫН ЗҮЙЛ	2021 он	2022 он
<b>1. ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1 Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгөн хөрөнгө	2,390,592,895.19	1,785,891,692.24
Дансны авлага	2,935,328,536.74	2,358,302,636.02
Татвар, шимтгэлийн авлага	120,912,688.64	120,239,669.23
Бусад авлага	5,923,245,156.80	3,643,731,827.34
Бараа, материал	5,432,423,325.51	10,904,852,225.20
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	2,728,717,470.30	2,857,479,500.61
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>19,531,220,073.18</b>	<b>21,670,497,550.64</b>
<b>1.2 Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	7,660,714,445.21	7,474,665,397.47
Биет бус хөрөнгө	11,404,337.86	3,921,570.81
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>7,672,118,783.07</b>	<b>7,478,586,968.28</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,203,338,856.25</b>	<b>29,149,084,518.92</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1 Өр төлбөр</b>		
Дансны өглөг	262,007,731.15	143,144,317.13
Цалингийн өглөг	65,398,229.12	123,770,014.13
Татварын өглөг	792,854,581.94	499,460,197.15
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг		
Богино хугацаат зээл		919,999,999.92
Урьдчилж орсон орлого		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг	1,050,000,000.00	
Бусад богино хугацаат өр төлбөр	25,011,704.72	1,618,238.10
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,195,272,246.93</b>	<b>1,687,992,766.43</b>
Урт хугацаат зээл	3,428,267,333.46	1,724,460,000.28
Урт хугацаат өр төлбөр		
Бусад урт хугацаат өр төлбөр	1,465,649.16	7,551,555.88
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,429,732,982.62</b>	<b>1,732,011,556.16</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,625,005,229.55</b>	<b>3,420,004,322.59</b>
<b>2.2 Эзэмшигчдийн өмч</b>		
Өмч а) хувийн	110,000,000.00	110,000,000.00
Нэмж төлөгдсөн капитал		
Эздийн өмчийн бусад хэсэг	380,000,000.00	380,000,000.00
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	21,088,333,626.70	25,239,080,196.33
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>21,578,333,626.70</b>	<b>25,729,080,196.33</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,203,338,856.25</b>	<b>29,149,084,518.92</b>

*Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



<b>ГАРЧИГ</b>	<b>ХУУДАС</b>
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ	1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2-3
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	4
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	5
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТҮЙН ТАЙЛАН	6
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	7
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8-16

# ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

НОМУУН БЭХИ АУДИТ ХХК-Д

Удирдлагын хариуцлагын захидал

Танай компани “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу манай 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж байгаатай холбогдуулан энэхүү захидлыг илгээж байна.

Олон улсын Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, холбогдох бусад хууль, журам, зааврын дагуу санхүүгийн тайлангаа шударгаар бэлтгэх нь бидний үүрэг хариуцлага гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Бид та бүхэнд нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, дэлгэрэнгүй болон ерөнхий данс, улирал бүрийн гүйлгээ баланс болон санхүүгийн тайлангуудыг мөн байгууллагын хөрөнгөтэй холбоотой удирдах дээд байгууллагуудаас ирүүлсэн тогтоол, шийдвэр, бусад бичиг баримтыг танилцуулсан.

Санхүүгийн тайланд тусгагдснаас өөр ямар нэгэн орлого, бусдад хадгалуулсан эсвэл ашиглуулж байгаа хөрөнгө, бүртгэлээс гадуур нээсэн харилцах, хадгаламжийн данс болон зээлийн данс байхгүй болно.

Хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд тавих хяналтыг сулруулаагүй. Хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу шударгаар хийж гүйцэтгэдэг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн аль нэгэн заалтыг зөрчсөн үйлдэл гараагүй бөгөөд байгууллагын хөрөнгөтэй холбоотой томоохон хэмжээний зарга маргаан үүсээгүй.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргаснаас хойш буюу энэхүү захидал бэлтгэсэн өдрийн байдлаар байгууллагын хөрөнгө, үйл ажиллагаанд онцгой өөрчлөлт гараагүй.

Бид байгууллагын санхүү, бүртгэл, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтай холбоотой та нараас зөвлөгөө авах шаардлагатай гэж үзсэн зүйлийг та нарт танилцуулсан бөгөөд байгууллагын хэмжээнд оршиж байгаа аливаа нэгэн зөрчил дутагдлыг та нараас нуугаагүй. Хэрэв та нарт танилцуулалгүй нуусан зөрчил дутагдал, алдаанаас болж байгууллагад ямар нэгэн хохирол учруулбал бид өөрсдөө хариуцах ёстойг ухамсарлаж байна.

Гүнээ хүндэтгэсэн:

..... /Ц.Ганбат/

**ЗАХИРАЛ**

..... /Л.Бүрэнчимэг/

**ЕРӨНХИЙ НЯГТЛАН БӨДОГЧ**

НОМУУН БЭХИ АУДИТ ХХК

Хуудасны дугаар: 1.

ТТМ1872 д. 6761925

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

2022 оны 12-р сарын 31

Үзүүлэлт	2021 он	2022 он
Борлуулалтын орлого /цэвэр/	<b>29,186,082,213.73</b>	<b>30,153,766,014.62</b>
Борлуулалтын өртөг	18,461,370,778.95	20,487,892,463.45
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>10,724,711,434.78</b>	<b>9,665,873,551.17</b>
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого	62,135,813.55	10,841,244.30
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	361,217,934	92,572,035.55
Борлуулалт, маркетингийн зардал	2,153,369,434	2,357,542,432.57
Ерөнхий ба удирдлагын зардал	1,382,250,534.38	1,665,656,813.23
Санхүүгийн зардал	325,464,570.56	417,176,278.22
Бусад зардал	677,185,408	601,649,102.79
Бусад ашиг /алдагдал/		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(6,327,046.34)	-37,015,680.04
Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз ( гарз )	(6,294,924.00)	-16,765,104.95
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	<b>6,597,173,265.05</b>	<b>4,673,481,419.22</b>
Орлогын татварын зардал	940,057,825.00	522,734,849.59
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>5,657,115,440.05</b>	<b>4,150,746,569.63</b>


*Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны 12-р сарын 31

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	Нийт дүн
<b>2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>110,000,000.00</b>			<b>380,000,000.00</b>	<b>17,436,247,955.65</b>	<b>17,926,247,955.65</b>
Залруулсан үлдэгдэл	110,000,000.00			380,000,000.00	17,436,247,955.65	17,926,247,955.65
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг					2,000,000,000.00	1,086,000,000.00
Тайлант оны ашиг, (алдагдал)					5,657,115,440.05	5,657,115,440.05
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>110,000,000.00</b>		-	<b>380,000,000.00</b>	<b>21,088,333,626.70</b>	<b>21,578,333,626.70</b>
Залруулсан үлдэгдэл	110,000,000.00			380,000,000.00	21,088,333,626.70	21,578,333,626.70
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
Тайлант оны ашиг, (алдагдал)					4,150,746,569.63	4,150,746,569.63
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>110,000,000.00</b>			<b>380,000,000.00</b>	<b>25,239,080,196.33</b>	<b>25,729,080,196.33</b>

*Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*





**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	2021 он	2022 он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>32,484,056,611.00</b>	<b>46,566,925,313.70</b>
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	32,246,831,248	46,522,900,144.81
Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого		
Хандив, тусламжийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан орлого		
Буцаан авсан албан татвар		
Бусад	237,225,363	44,025,168.89
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>25,847,308,328.65</b>	<b>45,384,018,999.34</b>
Ажиллагсдад олгосон мөнгө	2,492,373,615	1,345,562,889.30
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	718,142,624	935,000,001.00
Бараа материал худалдан авахад төлсөн	18,693,771,039	39,556,804,718.34
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	58,804,655	16,035,336.41
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	566,191,587	234,596,366.79
Хүүний төлбөрт төлсөн	291,274,521	294,341,187.22
Татварын байгууллагад төлсөн	2,182,475,803	2,111,878,424.36
Даатгалын төлбөрт төлсөн	3,705,095	212,760.00
Бусад мөнгөн зардалд	840,569,390	889,587,315.92
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>6,636,748,282.35</b>	<b>1,182,906,314.36</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,775,429,194.55</b>	<b>438,356.16</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,500,000.00	
Хүлээн авсан хүүний орлого	50,794,529.55	438,356.16
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт	1,720,134,665.00	
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>7,197,230,210.00</b>	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,038,336,758.00	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,276,250.00	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	6,146,617,202.00	
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,421,801,015.45)</b>	<b>438,356.16</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>331,531,329.01</b>	<b>2,598,018,295.86</b>
Зээл авсан	284,920,000.00	2,545,288,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Валютын ханшийн зөрүү	46,611,329.01	52,730,295.86
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,802,240,702.02</b>	<b>4,386,064,169.33</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн	954,192,080	3,299,439,178.26
Санхүү түрээсийн өглөгт төлсөн		20,320,354.54
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	39,317,662.10	66,304,636.53
Төлсөн ноогдол ашиг	808,730,960.00	1,000,000,000.00
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,470,709,373.01)</b>	<b>(1,788,045,873.47)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(255,762,104.88)</b>	<b>(604,701,202.95)</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,646,355,000.07</b>	<b>2,390,592,895.19</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,390,592,895.19</b>	<b>1,785,891,692.24</b>

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 1**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

---

**Байгууллагын талаарх мэдээлэл**

"Байгууллагын хаяг: УБ хот, Баянгол 20 хороо, үйлдвэрийн бүс, 66/2  
Утас: 99112827  
Регистрийн дугаар: 2577127  
Ерөнхий захирал: Ц.Ганбат  
Ерөнхий нягтлан бодогч: Л.Бүрэнчимэг  
Үйл ажиллагааны чиглэл: Нөөшилсөн хүнс үйлдвэрлэл, хүнсний ногоо савлаж худалдаалах, жимсний чанамал үйлдвэрлэх, хүнсний ногоо тарилах худалдаалах

**ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ**

Компанийн санхүүгийн тайлангуудыг компанийн үйл ажиллагаа тасралтгүй явагдана гэж үзсэн, мөн өмнөх зардлын түүх дээр үндэслэн бэлтгэсэн. Компанийн санхүүгийн тайлангууд нь үйл ажиллагааны тасралтгүй явуулах боломжгүй байдалд хүргэх нөлөө бүхий ямарваа нэг хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүн болон ангилалтай холбоотой залруулга агуулаагүй болно.

Санхүүгийн тайлан дахь мөнгөн дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд төгрөгөөр, мянганы оронд шилжүүлэн тайлагнасан болно.

**Нийцлийн мэдэгдэл**

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэсэн болно.

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД**

Компанийн санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхийн тулд удирдлага нь тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн тайлант дүн, болзошгүй өр төлбөрийн талаарх тодруулга болон тайлант тайлант хугацааны орлого, зардалын тайлант дүнд нөлөө үзүүлэх үнэлэмж, тооцоолол, төсөөллүүдийг хийх шаардлагатай болдог. Төсөөлөл, тооцооллуудын үнэлгээг байнга хийх ба эдгээр нь удирдлагын туршлага болон тухайн нөхцөл байдлын хувьд ирээдүйд тохиолдож болохуйц хүлээлт гэх мэт бусад хүчин зүйлүүд дээр суурилдаг. Гэхдээ эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болно.

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 2**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

---

**Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

**(1) Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг**

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ") -өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн.

**(2) Нягтлан Бодох Бүртгэлийн ерөнхий суурь**

Компанийн бүртгэлийн валют болох төгрөг, мөнгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчимын дагуу бэлтгэгдсэн.

**(3) Тасралтгүй үйл ажиллагааны зарчим**

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг баримталдаг. Үүнд:

**(4) Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс**

Тус компанийн мөнгө, түүнтэй адилтгах зүйлс нь мөнгөн хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкинд байршуулсан харилцах данс дахь мөнгө зэргээс бүрддэг.

**(5) Гадаад валютын ханшийн зөрүүгийн бүртгэл**

Сар, улирал, жилийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн харилцах дансны үлдэгдэл, гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөгийн үлдэгдэлд тухайн улирал, жилийн эцсийн өдрийн Монгол банкнаас тогтоосон ханшийг үндэслэн ханшийн тэгшитгэл хийдэг. Ханшийн зөрүүнээс үүссэн олз эсвэл гарзыг ханшийн зөрүүгийн бодит бус олз эсвэл гарзаар орлогын дэлгэрэнгүй тайланд хүлээн зөвшөөрдөг.

**(6) Дансны авлага**

Дансны авлага нь зээлийн борлуулалтаас үүссэн авлагыг бүс бүрээр тооцож бүртгэдэг. Компани нь найдваргүй авлагын нөөц байгуулдаггүй.

**(7) Урьдчилж төлсөн зардал, тооцоо**

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал, хөрөнгө гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал, тооцоо гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардал болон хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

**(8) Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө**

Эргэлтийн бус хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөн олж авах бол уг хөрөнгийг "Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө" гэж ангилна.

**(9) Үндсэн хөрөнгө**

Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл нь анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан. Барилга байгууламж нь өөрсдөө барьж байгуулсан өртгөөс, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгслийн анхны өртөг нь худалдан авсан үнээс бүрдэнэ.

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 2**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

---

**(10) Үндсэн хөрөнгийн элэгдэл**

Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгслийн элэгдлийг ашиглагдах хугацааных нь туршид шулуун шугамын аргаар байгуулж, орлогын дэлгэрэнгүй тайланд тусгадаг. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

Барилга байгууламж	25 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Компьютер, тоног төхөөрөмж	2 жил

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрт дахин тооцож үзнэ.

**(11) Богино хугацаат өр төлбөр**

Тайлант хугацааны эцсээс хойш 12 сараас илүүгүй хугацаанд буцаан төлөгдөх өр төлбөрт дансны өглөг, татвар, шимтгэлийн өглөг, цалингийн өглөг, ногдол ашгийн өглөг болон бусад өглөг, банк болон санхүүгийн байгууллагаас авсан зээл, урьдчилж орсон орлогыг бүртгэдэг.

**(12) Орлогын хүлээн зөвшөөрөлт**

Тус компанийн орлогын гол эх үүсвэр нь нөөшилсөн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын орлогоос бүрддэг. Борлуулалтын орлогыг буцаалт, хөнгөлөлтийг дүнг хассан цэвэр дүнгээр хэмждэг. Орлогыг аккрузл сууриар бүртгэдэг.

1) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт нөөшилсэн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэхтэй холбогдон гарсан шууд материал, шууд хөдөлмөр болон үйлдвэрлэлийн бусад нэмэгдэл зардлаас бүрддэг.

**(13) Зардлын хүлээн зөвшөөрөлт**

Тус компани нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлж байгаа тул мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран үйл явдал, ажил гүйлгээ хийгдсэн тухай тайлангийн хугацаанд нь хүлээн зөвшөөрч зардалд тусгадаг.

Хөрөнгө багасах буюу өр төлбөр нэмэгдсэний улмаас эдийн засгийн үр өгөөж буурч, улмаар энэ бууралтыг найдвартай хэмжих боломжтой байвал түүнийг зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ тухайн зардлыг түүнтэй холбоотой орох орлогод холбогдуулан тухайн тайлант хугацаанд хамааруулан бүртгэх бодлогыг баримталдаг.

**(14) Татварын бүртгэл, тооцоо**

Нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахйн нэгжийн орлогын албан татвар, ажиллагсад олгосон цалингаас суутган тооцсон татвар зэрэг тооцоог татварын байгууллагатай хийдэг.

Татвар, шимтгэл ногдуулалт, төлөлтийн талаар хүлээсэн үүргээ зохих хугацаанд нь хийж байсан.

**(15) Ажиллагсадын эрүүл мэнд ба нийгмийн даатгал**

Ажиллагсадын цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хуулийн дагуу даатгуулагч болон ажил олгогчийн нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тооцож төлдөг. Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлыг гарсан үед нь орлогын дэлгэрэнгүй тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

**(16) Урт хугацаат зээл**

Тайлант хугацааны эцсээс хойш 12 сараас илүү хугацааны дараа нөхөгдөх буюу барагдуулах өр төлбөрийг толилуулна.

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

2021 он болон 2022 оны эцэст тус компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

	2021	2022
Касс дахь мөнгө	1,150,270,470.90	418,600,456.39
Банкин дахь мөнгө	1,240,322,424.29	1,367,291,235.85
<b>Дүн</b>	<b>2,390,592,895.19</b>	<b>1,785,891,692.24</b>

**2. АВЛАГА**

2021 он болон 2022 оны эцэст тус компанийн авлагын үлдэгдэл дараах байдалтай байна.

**а. Дансны авлага**

	Дансны авлага	Дансны авлага /цэвэр дүнгээр/
Эхний үлдэгдэл	2,935,328,536.74	2,935,328,536.74
Нэмэгдсэн	43,375,580,754.27	43,375,580,754.27
Хасагдсан	43,952,606,654.99	43,952,606,654.99
<b>Дүн</b>	<b>2,358,302,636.02</b>	<b>2,358,302,636.02</b>

**б. Татвар, нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/-ийн авлага**

	2021	2022
НДШ-ийн авлага	10,846,147.70	
ХХОАТ-ын авлага		19,516,908.30
Бусад татварын авлага	106,526,311.00	100,722,760.93
<b>Дүн</b>	<b>117,372,458.70</b>	<b>120,239,669.23</b>

**в. Бусад богино хугацаат авлага**

	2021	2022
Холбоотой талаас авах авлага	5,923,245,156.80	3,643,731,827.34
<b>Дүн</b>	<b>5,923,245,156.80</b>	<b>3,643,731,827.34</b>

**3. БАРАА МАТЕРИАЛ**

	2021	2022
Түүхий эд материал	3,839,147,285.80	5,634,451,147.80
Бэлэн бүтээгдэхүүн	1,348,505,401.60	4,808,435,771.20
Бусад	244,770,638.10	461,965,306.20
<b>Дүн</b>	<b>5,432,423,325.50</b>	<b>10,904,852,225.20</b>

**4. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ**

2021 он болон 2022 оны эцэст тус компанийн урьдчилж төлсөн зардалд дараах байдалтай байна.

	2021	2022
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр	2,728,717,470.30	2,857,479,500.61
<b>Дүн</b>	<b>2,728,717,470.30</b>	<b>2,857,479,500.61</b>

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

2021 он 2022 оны эцэст тус компанийн үндсэн хөрөнгө дараах байдалтай байна.

	2021	2022
Газрын сайжруулалт	15,000,000.00	20,097,290.00
Барилга байгууламж	3,786,273,085.83	3,786,273,085.83
Машин, тоног төхөөрөмж	4,869,212,857.90	5,246,212,682.16
Тээврийн хэрэгсэл	1,080,008,602.27	1,143,067,933.64
Тавилга эд хогшил	175,106,025.34	174,044,847.30
Компьютер,бусад хэрэгсэл	95,315,555.28	102,796,191.65
Бусад үндсэн хөрөнгө	189,662,119.78	297,567,322.50
<b>Дүн</b>	<b>10,210,578,246.40</b>	<b>10,770,059,353.08</b>

**ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ**

	2021	2022
Газрын сайжруулалт	-	-
Барилга байгууламж	355,186,246.05	506,521,348.85
Машин, тоног төхөөрөмж	1,771,459,514.06	2,253,922,174.54
Тээврийн хэрэгсэл	208,354,402.71	277,013,844.30
Тавилга эд хогшил	45,358,254.99	62,090,376.13
Компьютер,бусад хэрэгсэл	85,872,264.60	95,504,329.49
Бусад үндсэн хөрөнгө	83,633,118.78	100,341,882.30
<b>Дүн</b>	<b>2,549,863,801.19</b>	<b>3,295,393,955.61</b>
<b>Нийт дүн</b>	<b>7,660,714,445.21</b>	<b>7,474,665,397.47</b>

**6. БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

2021 он 2022 оны эцэст тус компанийн биет бус хөрөнгө дараах байдалтай байна.

	2021	2022
Компьютерийн программ хангамж	11,404,337.86	3,921,570.81
<b>Дүн</b>	<b>11,404,337.86</b>	<b>3,921,570.81</b>

**БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ХОРОГДОЛ**


	2021	2022
Компьютерийн программ хангамж	-	-
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>11,404,337.86</b>	<b>3,921,570.81</b>

**7. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**

2021 он болон 2022 оны эцэст тус компанийн богино хугацаат өр төлбөр дараах байдалтай байна.

**а. Дансны өглөг**

	2021	2022
Төлөгдөх хугацаандаа байгаа	262,007,731.15	143,144,317.13
<b>Дүн</b>	<b>262,007,731.15</b>	<b>143,144,317.13</b>



**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

<b>б.Цалингийн өглөг</b>	<b>2021</b>	<b>2022</b>
Цалингийн өглөг	65,398,229.12	123,770,014.13
<b>Дүн</b>	<b>65,398,229.12</b>	<b>123,770,014.13</b>

<b>в. Татварын, НДШ-ийн өглөг</b>	<b>2021</b>	<b>2022</b>
ААНОАТ-ын өглөг	526,873,863.39	174,750,485.8
НӨАТ-ын өглөг	100,068,942.55	234,995,730.13
ХХОАТ-ын өглөг		64,946,359.88
Бусад татварын өр	165,941,776.00	24,767,621.36
<b>Дүн</b>	<b>792,884,581.94</b>	<b>499,460,197.15</b>

<b>г.Богино хугацаат зээл</b>	<b>2021</b>	<b>2022</b>
Төлөгдөх хугацаандаа байгаа		919,999,999.92
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>919,999,999.92</b>

<b>д.Богино хугацаат өр төлбөр</b>	<b>2021</b>	<b>2022</b>
Өр төлбөр	25,011,704.72	1,618,238.10
<b>Дүн</b>	<b>25,011,704.72</b>	<b>1,618,238.10</b>

<b>е.Урт хугацаат зээл болон бусад урт хугацаат өр төлбөр</b>	<b>2021</b>	<b>2022</b>
Гадаадын байгууллагаас дамжуулан авсан зээл	3,428,267,333.46	1,724,460,000.28
Бусад урт хугацаат өр төлбөр	1,465,649.16	7,551,555.9
<b>Дүн</b>	<b>3,429,732,982.62</b>	<b>1,732,011,556.16</b>

**8. ЭЗДИЙН ӨМЧ**


**а. Хувьцаа**

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн эздийн өмч нь энгийн хувьцаанаас бүрдэх бөгөөд Монгол Улсын иргэн 5, Герман улсын 1 иргэн эзэмшиж байна.

	Эргэлтэд байгаа энгийн хувьцааны тоо ширхэг	Өмчийн дүн
Эхний үлдэгдэл		110,000,000.00
Эцсийн үлдэгдэл		110,000,000.00

**б.Хуримтлагдсан ашиг**

Хуримтлагдсан ашиг дансанд 2022 онд 25,239,080,196.33 төгрөгийн ашиг, 2021 онд 21,088,333,626.7 төгрөгийн ашиг хуримтлагдсан байна.



**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**9.БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ**

2021 болон 2022 оны борлуулалтын орлого болон борлуулсан барааны өртөг дараах байдалтай байна.

	<b>2021</b>	<b>2022</b>
Бараа бүтээгдэхүүн борлуулсаны орлого		
Ажил, үйлчилгээ борлуулсаны орлого	29,186,082,213.73	30,153,766,014.62
Нийт борлуулалтын орлого	29,186,082,213.73	30,153,766,014.62
<b>Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт</b>		
<b>Цэвэр борлуулалт</b>	<b>29,186,082,213.73</b>	<b>30,153,766,014.62</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	18,461,370,778.95	20,487,892,463.45
Борлуулсан ажил, үйлчилгээний өртөг бүтээгдэхүүний өртөг		
<b>Дүн</b>	<b>18,461,370,778.95</b>	<b>20,487,892,463.45</b>

**9.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

2021 он болон 2022 оны эцэст тус компанийн үндсэн үйл ажиллагааны зардал дараах байдалтай байна.

**9.2 Ерөнхий ба удирдлагын зардал**

	<b>2021</b>	<b>2022</b>
Үндсэн ба нэмэгдэл цалин	700,691,142.00	620,285,111.00
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	117,227,772.32	96,803,029.51
Албан татвар хураамжийн зардал	44,429,039.67	59,386,535.00
Томилолтын зардал		38,123,003.99
Бичиг хэргийн зардал	5,044,125.10	7,844,168.50
Шуудан холбоо, интернет сүлжээний зардал	23,590,857.02	16,369,135.27
Сургалтын зардал	9,187,175.93	
Даатгалын зардал	2,282,073.00	2,436,473.52
Элэгдэл, хорогдлын зардал	130,387,992.69	132,262,102.38
Түрээсийн зардал	1,500,000.00	
Түлш, шатахуун тослох материалын зардал	26,750,080.25	43,370,856.86
Ашиглалтын зардал	26,923,863.16	39,794,184.96
Бусад зардал		240295736.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	88,185,831.18	290,425,829.88
Шагнал урамшууллын зардал	473,545.45	
Хангамжийн материалын зардал	29,413,538.79	
Засвар үйлчилгээний зардал	51,825,818.19	44,503,800.28
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	124,337,679.63	
татварын зардал		1,795,473.36
Ёслол хүндэтгэлийн зардал		31,961,371.9
<b>Дүн</b>	<b>1,382,250,534.38</b>	<b>1,665,656,813.23</b>



**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**9.3 Борлуулалт ба маркетингийн зардал**

	<b>2021</b>	<b>2022</b>
Үндсэн ба нэмэгдэл цалин	1,116,717,055.00	1,147,338,250.00
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	160,753,787.84	156,396,048.96
Албан татвар хураамжийн зардал	1,973,975.00	2,490,681.82
Томилолтын зардал		516,636.36
Бичиг хэргийн зардал	1,170,620.00	1,644,110.35
Шуудан холбоо, интернет сүлжээний зардал	8,336,137.19	7,655,720.94
Сургалтын зардал	3,393,636.58	2,696,059.33
Даатгалын зардал	1,674,530.00	2,114,382.00
Ашиглалтын зардал	6,048,657.98	12,921,002.76
Элэгдэл, хорогдлын зардал	32,215,409.95	39,141,529.22
Түрээсийн зардал	36,952,591.02	40,221,819.10
Тээврийн зардал	261,482,076.86	154,025,793.10
Түлш, шатахуун тослох материалын зардал	103,767,946.66	148,617,140.28
Зар сурталчилгааны зардал	34,959,648.22	145,631,199.04
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	91,542,125.64	129,973,915.13
Хангамжийн материалын зардал	10,203,200.15	8,169,433.24
Засвар үйлчилгээний зардал	54,943,261.91	72,994,192.46
Бүтээгдэхүүн урамшууллын зардал	8,638,069.53	
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	218,596,704.51	284,994,518.48
<b>Дүн</b>	<b>2,153,369,434.0</b>	<b>2,357,542,432.57</b>

**9.4 Бусад зардал**

	<b>2021</b>	<b>2022</b>
Алданги торгуулийн зардал	8,563,000.00	305,500.00
Бусад	668,622,408.00	601,343,602.79
<b>Дүн</b>	<b>677,185,408.00</b>	<b>601,649,102.79</b>

**10.БУСАД ОРЛОГО**

2022 он болон 2021 оны эцэст бусад орлого дараах байдалтай байна

**а.Бусад орлого**

	<b>2021</b>	<b>2022</b>
Бусад орлого	361,217,934	92,572,035.6
<b>Дүн</b>	<b>361,217,934.00</b>	<b>92,572,035.55</b>

**б.Гадаад валютын ханшийн зөрүүний олз,гарз**

	<b>2021</b>	<b>2022</b>
Бусад ханшийн зөрүүний ашиг,алдагдал	(6,327,046.3)	(37,015,680.0)
<b>Дүн</b>	<b>(6,327,046.34)</b>	<b>(37,015,680.04)</b>

**11.ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ**

2022 он болон 2021 оны эцэст тус компанийн орлогын татварын зардал дараах байдалтай байна

	<b>2021</b>	<b>2022</b>
Орлогын татварын зардал	938,592,175.8	513,626,580.8
Хойшлогдсон татварын зардал/орлого/	1,465,649.2	9,108,268.8
<b>Дүн</b>	<b>940,057,825.00</b>	<b>522,734,849.59</b>

**"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 3**  
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

---

**11.ЦЭВЭР АШИГ**

Тус компани нь 2021 оны тайлант үед 5,657,115,440.05 төгрөгийн ашигтай, 2022 онд 4,150,746,569.63 төгрөгийн ашигтай ажилласан байна.

**12. ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал одоогийн байдлаар илрээгүй.

**13.БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ**

2022 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийгдэх хугацаанд компанийн хөрөнгө, үйл ажиллагаанд онцгой өөрчлөлт ороогүй.